


  
 БАТЛАВ:
   
 ЦАГДААГИЙН ТЭРГҮҮН ГЕНЕРАЛ ДЭД ДАРГА, ГАЗРЫН БРИГАДЫН
   
 Ц.НЯМ-ОЧИР
   
 2023 оны дугаар сарын 13-ны өдөр

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2023.04.13

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Хугацаа	Хариуцах алба, нэгж	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
<b>Нэг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийн хүрээнд:</b>					
1.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан нэгжийн үйл ажиллагааг бэхжүүлж, урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгон, улсын хэмжээнд нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх.	жилдээ	УСХ	ЭЦА МБА НХЖХОНАБХА ТЦА ЭкоЦА ХТТГ	Урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгож, улсын хэмжээнд нэгдсэн нэг бодлогоор ажил, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлснээр давхардалгүйгээр нэг удирдлагаар хангагдана.
2.	Байгууллагын дотоодод болон эрхлэх асуудлын хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталж, холбогдох алба хаагчдад хариуцуулан хэрэгжүүлэх. /ГХУСА33-1.1/	жилдээ	УСХ	ГБХХЭГХТХ НДХЦБ	Төлөвлөгөөний дагуу ажил арга хэмжээ нь хариуцах эзэнтэй болсноор төлөвлөгөөний биелэлт хангагдаж үр дүн гарна.
3.	Зохицуулах зөвлөлийн гишүүд эрхлэх асуудлын хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтэн томилж, ажиллуулах /ГХУСА33-1.2/	жилдээ	УСХ	НДХЦБ	Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланг Ажлын албанд хургуулсан байна.
4.	Мэргэжлийн байгууллагаас түгээж байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх инфографик, шторк, контент болон сэрэмжлүүлгийг салбар, байгууллагын цахим хуудас, сайтаар тогтмол байрлуулж, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх. /ГХУСА33-1.3/	жилдээ	УСХ, ХМТ	ЦДЦАБ	Иргэдийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг дээшилнэ.
5.	Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж буй төрийн байгууллагын үйл ажиллагаанд судалгаа хийж авлигын эрсдлийг тодорхойлох, үйлчилгээг иргэдэд шурхай хүргэх боломжийг бүрдүүлэх. /ГХУСА33-1.4/	жилдээ	ДХАБГ	ЦДЦАБ	Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланг Ажлын албанд хургуулсан байна.
6.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг хэвлэл мэдээллийн байгууллага үнэ төлбөргүй нийтэлж, нэвтрүүлэх журмын төслийг боловсруулж, батлуулах. /ГХУСА33-1.6/	жилдээ	ХуХ	ЦДЦАБ	Журмын төсөл батлагдсан байна.

7.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх хөрөнгийг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, тайлагнах болон Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг урамшуулах журмыг боловсруулж, батлуулах. /ГХУСА33-1.7/	жилдээ	ХуХ	ЦДЦАБ	Хамтарсан тушаалаар журмын төсөл батлагдсан байна.
8.	Олон Улсын төсөл болон Үндэсний хөтөлбөр /Монгол Улсад хүүхдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдаалах, хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн Хүүхэд хамгааллын компакт гэрээний болон НҮБ-ын Хүн амын сангийн "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл"-ийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнийг хэрэгжилтийг хангах гэмт мэт/-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх. /ГХУСА33-1.8/	жилдээ	ЭЦА ГБХХЭГХТХ	НДХЦБ	Хөтөлбөрийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, дүгнэсэн байна.
9.	Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах. /ГХУСА33-1.9/	жилдээ	ЭЦА ЭмЦА НХЖХОНАБХА ХТТГ ГБХХЭГХТХ	НДХЦБ	Төлөвлөгөө батлагдаж хэрэгжсэн байна.
10.	Ерөнхий боловсролын 10-12 дугаар ангийн сурагчид, их дээд сургуулийн эрх зүйн бус мэргэжлийн ангийн 1, 2 дугаар дамжааны оюутнууд, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад эрх зүйн мэдлэг олгох албан бус сургалтыг нийслэлийн хэмжээнд эхлүүлэх ажлыг зохион байгуулах. /ГХУСА33-1.10/	жилдээ	ХТТГ ГБХХЭГХТХ УСХ	НДХЦБ	Сургалтад 10000-аас доошгүй сурагч, оюутан хамруулсан байна.
11.	Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох нэгдсэн сангийн ашиглалт, хүртээмжийг нэмэгдүүлж, сайжруулах. /ГХУСА33-1.12/	жилдээ	МДШШУА ЭХБГ	НДХЦБ	Сангийн хэвийн ажиллагааг хангаж хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.
12.	"Гэмт хэргийн цагаан ном-2022" эмхтгэлийг бэлтгэн гаргах. /ГХУСА33-1.13/	II улирал	МДШШУА		"Гэмт хэргийн цагаан ном-2022" эмхтгэл хэвлэгдсэн байна.
13.	Гадаадад гэмт хэргийн хохирогч болсон иргэдэд үзүүлж буй эрх зүйн болон санхүүгийн дэмжлэг тусалцааг нэмэгдүүлэх. /ГХУСА33-1.15/	жилдээ	ЭЦА	Холбогдох байгууллага	Эрх зүйн болон санхүүгийн дэмжлэг нэмэгдсэн байна.
14.	Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон улсын сайн туршлагыг хэрэгжүүлэх боломжийн чиглэлээр хэлэлцүүлэг зохион байгуулах. /ГХУСА33-1.16/	I-II улиралд	ТЦА	НДХЦБ	Хэлэлцүүлэг зохион байгуулж, зөвлөмж хүргүүлсэн байх.
<b>Хоёр. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай чиглэлийн хүрээнд:</b>					
<b>2.1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр</b>					
15.	Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрыг шинээр болон бусчлэн байгуулах ажлыг эрчимжүүлэх, мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулах. /ГХУСА33-2.1.1/	жилдээ	НХЖХОНАБХА	НДХЦБ	ТЭЗҮ-ийн дагуу барилгын ажлыг эхлүүлсэн байна.

16.	Зэрлэг байдлаар ургаж буй мансууруулах үйлчилгээтэй ургамлыг устгах ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран тархац тогтоогдсон аймгийн нутаг дэвсгэрт зохион байгуулах. /ГХУСА33-2.1.2/	II, III улирал	ХТТГ	НДХЦБ	Устгалын арга хэмжээ зохион байгуулагдсан байна.
17.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллагад шаардлагатай програм хангамж, техник хэрэгсэл, багаж нийлүүлэх. /ГХУСА33-2.1.3/	жилдээ	ХТТГ	Энэ чиглэлээр мэргэшсэн байгууллага	Холбогдох хууль тогтоомжийн дагуу хөрөнгө оруулалт хийгдсэн байна.
<b>2.2. Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр</b>					
18.	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллах, дэмжлэг үзүүлэх. /ГХУСА33-2.2.1/	жилдээ	ЭЦА	Төрийн бус байгууллага	Ажлын даалгаврын дагуу холбогдох ажил, арга хэмжээ зохион байгуулагдаж, үр дүнг тооцсон байна.
19.	Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллагын алба хаагчдыг мэргэшүүлэх сургалт зохион байгуулах. /ГХУСА33-2.2.2/	жилдээ	ЭЦА МБА СГАСХ	НДХЦБ	Сургалт зохион байгуулагдаж, үр дүнг тооцсон байна.
20.	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч иргэдийг зохих сургалтад хамруулж, ажлын байраар хангах чиглэлээр холбогдох арга хэмжээ авах. /ГХУСА33-2.2.3/	жилдээ	ЭЦА		Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулж, ажлын байраар хангасан байна.
<b>2.3. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх</b>					
21.	"Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд салбар хоорондын олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх нь" сэдэвт Үндэсний чуулган зохион байгуулах. /ГХУСА33-2.3.1/	жилдээ	ГБХХЭГХТХ	Холбогдох байгууллага	Үндэсний чуулган зохион байгуулагдаж, зөвлөмж гарсан байна.
22.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийлгэх. /ГХУСА33-2.3.2/	жилдээ	ГБХХЭГХТХ	Холбогдох байгууллага	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт хангагдаж, хохирогчид үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар дээшилнэ.
<b>2.4. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх</b>					
23.	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг аймгийн сумдын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, хэсгийн төлөөлөгч, экологийн асуудал хариуцсан байцаагч, хэсгийн байцаагч /хуулиар хүлээсэн бусад субъект/ нарыг чадавхжуулах салбар дундын зөвлөгөөн зохион байгуулах. /ГХУСА33-2.4.1/	жилдээ	ЭкоЦА	БОАЖЯ НДХЦБ	Зөвлөгөөн зохион байгуулагдаж санал, зөвлөмж гарч, холбогдох байгууллагуудад хүргэгдсэн байна.
24.	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох байгууллага, аж ахуйн нэгжид мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулах /газар, газрын хэвлий, хөрс, ойн сан, усны нөөц, амьтан ургамал, байгалийн дагалдах баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, хожирол нөхөн төлүүлэх/ арга хэмжээ авах. /ГХУСА33-2.4.2/	жилдээ	ЭкоЦА	Холбогдох байгууллага НДХЦБ	Мэргэжлийн байгууллагаас заавар, зөвлөмж хүргүүлж зөрчил буурсан байна.

25.	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд "Байгалиа хамгаалья" олон нийтийг соён гэгээрүүлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах. /ГХУСА33-2.4.3/	жилдээ	ЭкоЦА	ЦДЦАБ	Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар иргэдийн мэдлэг, ойлголт дээшилж, урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоо нэмэгдсэн байна.
26.	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллагын алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулах. /ГХУСА33-2.4.4/	жилдээ	ЭкоЦА	ЦДЦАБ Холбогдох байгууллага	Гадаад улс орны гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тэргүүн туршлагыг судалж, алба хаагчдын мэдлэг, ур чадвар дээшилсэн байна.
<b>2.5. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай</b>					
27.	Маршрутын бус замаар /хулгайн замаар/ нийслэлд мал, мах болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэн нэвтрүүлж байгаатай холбогдуулан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтарсан хяналт шалгалт зохион байгуулах. /ГХУСА33-2.5.2/	жилдээ	ЭЦА	НДХЦБ	Маршрутын бус замаар мах болон малын гаралтай бүтээгдэхүүн тээвэрлэх зөрчил буурна.
<b>2.6. Цахим гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр</b>					
28.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд инноваци нэвтрүүлэх, цахим технологи ашиглах хөгжүүлэлтийг нэмэгдүүлэх. /ГХУСА33-2.6.2/	жилдээ	МДШШУА	Холбогдох байгууллага	Судалгаа хийгдэж, санал, зөвлөмж хүргүүлсэн байх.
<b>Гурав. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн чиглэлийн хүрээнд:</b>					
29.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд авто зам, замын байгууламжийн стандарт, шаардлага, технологийн горимд тавих хяналт, хариуцлага, түүний үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээ авах. /ГХУСА33-3.1/	жилдээ	ТЦА	НДХЦБ	Авто зам, замын байгууламжаас шалтгаалсан зам тээврийн осол үүсгэж болох эрсдэлт нөхцөл байдал буурна.
30.	Ой, ан, байгалийн ургамлын ашиглалт, хамгаалалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт, шалгалт хийх. /ГХУСА33-3.2/	жилдээ	НХХХОНАБХА ЭкоЦА	НДХЦБ	Улсын хэмжээнд 1-зэс доошгүй нэгдсэн шалгалт хийгдсэн байна.
31.	Гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгүүлж суллагдсан хүнд хяналт тавих тогтрлоо, зохион байгуулалтыг боловсронгуй болгох. /ГХУСА33-3.3/	жилдээ	ЭЦА НХХХОНАБХА	НДХЦБ	1-зэс доошгүй оновчтой шийдлийг хэрэгжүүлсэн байна.
32.	Иргэдийн оролцоотой замын хөдөлгөөний хяналтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд E-Police цахим программ ашиглан замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийг хангуулах ажлыг судалж, боловсронгуй болгох. /ГХУСА33-3.4/	жилдээ	ТЦА	НДХЦБ	Зөрчлийн мэдээллийг ашиглан замын хөдөлгөөний дүрмийг баримталдаггүй жолооч нарыг иргэд, олон нийтийн тусламжтайгаар зөрчлийг илрүүлэх, дүрэм баримтлах хандлагыг төлөвшүүлнэ.
33.	Замын хөдөлгөөний зохион байгуулалт, аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд гэрээт болон олон нийтийн цагдаа, олон нийтийн байцаагчийг ажиллуулах. /ГХУСА33-3.5/	жилдээ	ТЦА	НДХЦБ	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон нийтийн хандлага, мэдлэг ойлголт нэмэгдэж, зөрчлийн гаралт буурна.


Дөрөв. Соён гэгээрүүлэх чиглэлээр:					
34.	Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон соён гэгээрүүлэх чиглэлээр инфографик, шторк, контент болон цуврал нэвтрүүлэг бэлтгэж олон нийтэд түгээх. /ГХУСА33-4.1/	жилдээ	ХМТ УСХ	ЦДЦАБ	Тайлангийн хугацаанд инфографик 100, шторк 50, контент 50, цуврал нэвтрүүлэг 40-өөс доошгүйг бэлтгэж, олон нийтэд түгээсэн байна.
35.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэтгүүлчдэд зориулсан сургалт зохион байгуулах. /ГХУСА33-4.2/	жилдээ	ХМТ	УСХ	Сургалтад хамруулж, үр дүнг тооцсон байна.
36.	Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр алба хаагчдыг чадавхжуулах. /ГХУСА33-4.5/	жилдээ	МБА	НДХЦБ	Алба хаагчдыг сургалтад хамруулж, үр дүнг тооцсон байна.
37.	ЕБС-ийн сурагчдын дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор "Өсвөрийн сэргийлэгч" бүлгэмийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, үе шаттай тэмцээн зохион байгуулах. /ГХУСА33-4.6/	жилдээ	ГБХХЭГХТХ	НДХЦБ	Улсын хэмжээнд зохион байгуулагдаж, үр дүнг тооцсон байна.
38.	Төрийн алба хаагчдад төрийн, байгууллагын болон хувь хүний нууцтай холбоотой хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулах. /ГХУСА33-4.7/	жилдээ	ТНТ	ЦДЦАБ	Сургалт зохион байгуулагдаж, үр дүнг тооцсон байна.
39.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл үзүүлж байна "Сэргийлэгч" нэвтрүүлгийг бэлтгэн, олон нийтэд хүргэх. /ГХУСА33-4.8/	жилдээ	ГБХХЭГХТХ УСХ	Алба, нэгж НДХЦБ	Нэвтрүүлгийн хуваарь гарч, олон нийтийн хүртээл болсон байна.
40.	"Ногоон гэрэл-Цагаан шугам", "Замын хөдөлгөөний цагаан толгой" тэмцээний хөтөлбөрийг шинэчлэх, улсын хэмжээнд зохион байгуулах. /ГХУСА33-4.9/	III улирал	ТЦА	НДХЦБ	Замын хөдөлгөөнд оролцогч хүүхдүүдийн анхаарал сэрэмж дээшилж, осол, гэмтлийн тохиолдол буурна.

ХЯНАСАН:  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЭЛТСИЙН ДАРГА  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Г.АРСЛАНХУЯГ

БОЛОВСРУУЛСАН:  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,  
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА



Ц.НАРАНТУЯА